



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн  
Монгол дахь хөтөлбөрийн газар

## Байгаль орчны мэдээ

2006-09-22

### ХУЛГАР ШАРЫГ ХОВОР АМЬТНЫ ЖАГСААЛТАД ОРУУЛАГЧДЫН МӨРӨӨР

**Мэдээг бэлтгэсэн: Ё.Онон, О.Мөнхтогтох**

Хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-1, Ирвэс-3 шуурхай багийн бүрэлдэхүүн Монгол улсын Амьтны аймгийн тухай хууль, Байгаль орчны сайдын 2005 оны 1-р сарын 6-ны өдрийн №01 тоот тушаалын хэрэгжилтэнд хяналт тавих, тарваганы хууль бус агнуурын зөрчлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор Увс, Ховд аймагт 2006 оны 8 дугаар сарын 4-нөөс 9 дүгээр сарын 8 хүртэл хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийлээ.

Ирвэс-1 шуурхай багийн хяналт шалгалтын дүнгээр Увс аймгийн Бөхмөрөн суманд 31 өрх, 78 хүн хамрагдаж, 23 зөрчил таарснаас 14 зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авсан байна. Нийт 18 ширхэг хавх, 9 ширхэг ТОЗ-8 маркийн буу, бие гүйцсэн тарваганы арьс 28 ширхэгийг, мөндлийн арьс 15 ширхэгийг хурааж, 100 мянган төгрөгийн торгууль, 3 575 000 (гурван сая таван зуун далан таван мянган) төгрөгийн нөхөн төлбөр ногдуулжээ. Хяналтын ажлын дүнг Бөхмөрөн сумын засаг даргын зөвлөлд тавьж хэлэлцүүлэн цаашид авах арга хэмжээний талаар санал солилцсон байна.



Бөхмөрөн сумын иргэн Давхарбаяр

Ирвэс-3 шуурхай баг Ховд аймгийн Чандмань, Манхан, Цэцэг, Дуут, Мөст, Мөнххайхан, Алтай сумдын нутагт хийсэн

шалгалтын дүнгээс үзвэл нийт 15 ширхэг хавх, 12 ширхэг ТОЗ-8 маркийн буу, 130 ширхэг тарваганы арьс, бусад түүхий эдийг хурааж, сая гаруй төгрөгийн нөхөн төлбөр, торгууль ногдуулжээ. Ховд аймгийн Алтай суманд тарваганы хууль бус агнуур илүү их байгаа нь алслагдсан сумдад төдийлэн хяналт, шалгалт хийдэггүй, сурталчилгаа муу байгаатай шууд холбоотойгоос гадна “намайг хэн хэлэхэв, нохойг хэн саахав” гэсэн шүү хэнэггүйрхэл ч ажиглагдсан байна.



Ийнхүү хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-1, Ирвэс-3 шуурхай багууд хариуцсан нутаг дэвсгэртээ тус тусдаа хэсэгчилсэн хяналт, шалгалт хийсний дараа хамтарсан хяналт шалгалтыг Говь-Алтай аймагт хийв. Энэ удаагийн хяналт, шалгалтыг бөхөнгийн тархац нутаг болох Говь-Алтай аймгийн Дарви, Шарга сумдад зохион байгуулав. Хамтарсан хяналт шалгалтад Ирвэс багуудаас гадна Говь-Алтай аймгийн Дарви сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч П.Ганхуяг, хэсгийн төлөөлөгч, дэслэгч Х.Батсайхан, мөн идэвхтэн байгаль хамгаалагч (бөхөн хамгаалагч) - Д.Чин-Үнэн, Ц.Гантулга, Т.Ганзориг, Ш.Сэрсэндэмид нар оролцлоо. Ингээд

хамтарсан хяналт, шалгалтын хоёр өдрийн үйл явдлын талаар доор өгүүлэе. 2006 оны IX сарын 14-ны өдрийн нэг цагт Ховд аймгийн төвөөс Ирвэс багууд хөдлөн 230 км зам туулж оройн есөн цаг дөхөж байхад Дарви сумын Буянт багийн төвд ирэв. Бид бөхөн хамгаалагч нартайгаа уулзаж ярилцаад маргаашийн ажлаа хамтран төлөвлөөд энд хоноглов.

2006 оны IX сарын 15-ны 9 цагийн орчимд өглөөний цайгаа ууж дуусаад ойр орчмыг дурандаж байтал мотоциклтой хоёр хүн биднээс 2 км-ийн зайд тарваганы нүхэнд хавх тавьж байгаа нь харагдав. Хоёр баг зэрэг хөдлөв. Нэг баг машинаа далдлан тавьж, өндөрлөгөөс дурандаж, мотоциклтой 2 хүний үйл, хөдлөлийн талаар нөгөө багтаа мэдээлж байв. Хэт богино долгионы холбоогоор өвч тоногдсон тул мэдээллийн урсгал хоёр тал руу амьсгалын тоогоор хурдалж байв. Ажиглагч багийн удирдлагын дагуу Ирвэс-1 шуурхай баг ухасхийж нөгөө хоёр хүн дээр буух нь тэр. Ховд аймгийн Дарви сумын иргэн С.Хуяг-Очир, М.Төмөрхүрэл 5 ширхэг хавх тавьж байсныг таслан зогсоож, хавхыг хураан авч, 10000 төгрөгийн торгууль тавив.



Ховд аймгийн Дарви сумын иргэн С.Хуяг-Очир, М.Төмөрхүрэл

Тэдгээр хүмүүст яриа, таниулга хийж байх зуур уулын аманд майхнаас утаа гарч байхыг ажигласан Ирвэс-3 баг тэр зүг довтолгосон хэдий ч гурван морьтон аль хэдийн сэжиг авч уул өөд зугатааж амжсан. Арсалдсан хад асгатай Алтайн ууланд автохүлэг явганаас долоон дор аж. Морьтон монгол дэлхийн талыг эзлэхэд хүлэгийн давуу үнэхээр байжээ. Зугтагсадын отог дээр майхан, хоол хүнс, сав суулга, дөрвөн тарвага гэхчлэн бас бус зүйл байсан нь дан ганц тарвагачилах зорилгоор их Сутай уулын ар суганд хавчуудагдсан нь энэ ажгуу. Бүх зүйлийг баримтжуулан, тарвагыг хураагаад, “тарвага агнавал хуулийн ямар хариуцлага

хүлээхийг харуулсан сурталчилгааны материал” аяган доогуур нь шургуулаад, үүнийг уншиж нэгийг бодох буй за хэмээх найдлага тавиад гэдрэг эргэв.



Тарвагачдын орхисон отог дээр

Нэг цаг хагасарч байхад мотоциклтой хоёр хүн Сутай уулын амнаас гэнэт гарч ирэв. Тарвагчид, Ирвэс-1 багийнхан бие биенээ бараг зэрэг харав. Ирвэс-1 баг тэднийг шууд чиглэн явтал 2 км орчмоос зугатаж, өгсүүр бараадав. Өндөрлөгийг нь бариад алсуур гараад иртэл бэл рүү зугтаав. Ирвэс-3 баг уулын аманд отолт хийж байлаа. Зугтагсад жалга руу ороод 2 багийн аль алинд нь ч харагдахаа болив. Гүн жалганд нуугдчихлаа, шахалт, отолтод орсон тэд хаачихав гэсээр цаг орчим эртэл аль хэдийн газрын гав руу оржээ. Алдаа мэдгээ тунгаан дараагийн ажиллагаанд мотоцикло хэрэглэхээр тогтож, Говь-Алтай Дарви сум руу хөдөлцгөөв. Бидний замд N 46.40.448, E 93.49.715. солбицолд 4 янзага, 4 ооно, 16 шаргачинтай бөхөнгийн сүрэг тааралдав.

Гурав хорь гэхэд Говь-Алтай аймгийн Дарви суманд хүрэлцэн ирэв. Ирвэс-3 багийн гишүүн Б.Батсайханыд ирж, бөхөн хамгаалагч нартайгаа ажил төрлийн яриа өрнүүлж, цаашид хэрхэн ажиллах, идэвхтэн



Бөхөн хамгаалагчдын уулзалт

байгаль хамгаалагчийг урамшуулах журам,

түүний дагуу хийх гэрээ хэлцэл гэсээр оройн 10 цагт ажлаа дуусгаж, маргаашаа төлөвлөөд Ирвэс-1 баг Дарви сумын хэсгийн төлөөлөгч, дэслэгч Х.Батсайханыг, Ирвэс-3 баг сумын байгаль орны хяналтын улсын байцаагч П.Ганхуягийг авч, идэвхтэн байгаль хамгаалагчдаа дадлагуулах зорилгоор хоёр багт хуваарилав.

Хулгар шарын ангуучдын байрлалд дөхөж хоноглохоор 24 цагийн үед хоёр тийш сэм хөдөлж, харанхуйгаар сумаас гарцгаав. Хяналт, шалгалт хийх тухай мэдээллийг орон нутагт түгээхгүйн үүднээс “Ирвэс шуурхай багууд, бөхөн хамгаалагчдын хамтарсан семинар Дарви суманд 2-3 хоног үргэлжилнэ” гэсэн мэдээллийг өмнө нь цацсан байлаа. Дарви суманд үүрэн телефоны сүлжээ энэ онд тавигдаж ард олныг гялайлгасан ч энэ хөгжил дэвшил бидний ажилд саад болох магадлалтай байв. Сумын төв гэдэг алганы хотхор лугаа ил задгай толь, мэнд мэндээд араас нь угсруулдаг мэдээлэл бол ирэгсэд, явсадын үйл хөдлөл гэдгийг юу эс андахав.

Миний бие Ирвэс-1 багийн бүрэлдэхүүнд орж ажиллав. Энэ нь амьтан хамгааллын мэргэжилтэн, Улсын мэргэжлийн хяналтын газраас надад олгосон байгаль орчны хяналтын улсын байцаагчийн үүрэг юм. Манай багт Говийн их дархан газрын “Б” хэсгийн байгаль орчны байцаагч Д.Чин-Үнэн, идэвхтэн байгаль хамгаалагч Ш.Сэрсэндэмид, Увс аймгийн Бөхмөрөн сумын байгаль орчны байцаагч Р.Мандах нар хүч нэмж оролцов. Бид Дарви сумын төвөөс 28 км яваад, шөнийн нэг цагт нэгэн отгийг зорьж ирлээ. Энд бөхөнгийн нүүдэл, шилжилтийг судлахаар түүнийг барьж, сансрын болон газрын станциар дамжуулан тогтмол мэдээлэл авдаг хүзүүвч зүүж, суллан тавьж байсан юм. Дашрамд дурьдахад байнгын хяналтад буй бөхөнд халдаж хөгөө хөлдөө чирэв гэдгийг анхааруулахад илүүдэхгүй болов уу.

Хэсгийн төлөөлөгч, дэслэгч Х.Батсайханы авсан мэдээллийн дагуу шөнийн 6 цаг гэхэд тарвагачдын отоглож байсан газар ирцгээв. Харанхуйд зугааалгах магадлалтай тул 7 цаг өнгөрөөж, гэгээ оронгуут мотоциклтой, машинтай баг бүслэлт хийхээр эрэлд гарсан ч магадлал бүхий дөрвөн газарт тарвагачид байсангүй. Үүрэн телефоны сүлжээ барьдаг тул мэдээлэл авч биднээс урьтаж шөнө дөлөөр хөдөлснийг үгүйсгэхгүй.

Арван цагт арван минут дутуу байхад уулын амны битүү мухарт нэг жижиг гэр

харагдлаа. Тактикийн асуудлаа хөөрөлдөөд эцэст нь намайг, Ирвэс-1 багийн нэг гишүүний хамтаар арьсны ченж эмэгтэйн дүрд тоглуулахаар шийдвэрлэв. Ирвэс-1-ийн машины хаалган дээрх ирвэсийн зурагтай таних тэмдгийг цагаан цаасаар дарж скочдоод, хэсгийн төлөөлөгч, ирвэс-1 багийн ахлагч нар дээл өмсөж төрийн хувцасаа далдлан машиндаа сууж байхаар тохиров. Машин гэрийн чанх ард тулж, урд нүүрээ харуулан тормоз гишгэхэд даалгавар авсан хоёр жүжигчин ченжүүд гэрт орцгоов. Гэрт 18-20 насны дөрвөн залуу байв. Гэрийн доторх ундуй, сундуй, эзэд харин сандралдангуй. Тоононоос тогто руу татсан уяан дээр мөндөлний арьс өлгөөтэй, тарваганы мах, өөх тосны ямар ч сүрчгэнд дарагдахааргүйгээр хамар нэвтлэм үнэр танар биднийг угтлаа. Мэнд мэдэлцээд ченжүүд бид наймааныхаа ажилд орцгоов. Яриан дундуур нэг залуу гарч машин ажаад орж ирэв. Тэр хавиас бөөнөөр арьс авах ажил маань ч урагштай биш бололтой. Учир юу гэвэл хулгайн тарвагачид машин харангуут эргүүл гээд зугтаачихна хэмээн хөвүүд хүүрнэв. Удалгүй үнэ ханшаа тохиролцоод залуус арьсаа хоёр гартаа барьсаар гэрээс гарч, машинд дөхтөл хэсгийн төлөөлөгч, Ирвэс-1 багийн ахлагч нар дүрэмт хувцастай гэнэт буух нь тэр.



Миний ажил дууссан хэдий ч яг энэ агшинд бие минь чичэрч, өөрөө хулгай хийсэн юм шиг болж, зүрх маань бараг зогсчих шахсансан. Уулздаггүйн улаан даваан дээр учирсан хүмүүс учир зүйгээ олж, хуулийн өмнө буруугаа хүлээгээд, 2 буу, 2 хавхаа хураалгаж, 210000 төгрөгний нөхөн төлбөр, торгууль төлөхөөр болцгоов. Говь-Алтай аймгийн Шарга сумын иргэн Ч.Нямрагчаа, Б.Даваабаатар нарын зөрчилд цэг тавьж, төгсгөлд нь тарваганы хууль бус агнуурын хор холбогдлыг тусгасан сурталчилгааны материалаа тараагаад дараагийн ангуучлалд гарлаа.

Дарвийн нурууны салаа, сархиаг, хотхор, хотос дамжин явсаар түр үдлэв. Үдийн цай мотоциклтой хүнийг харах боломж олголоо. Тэр даруйд манай хоёр хүн мотоциклоо асаан хурдалж, удсан ч үгүй нөгөө хүнтэй хамт ирлээ. Тэрээр эрэлчин ажээ. Түүнийг ширтэж, ажиж байгааг харвал бидний нүд ер нь юмыг энгийнээр харахаа больж, сэрдэж сонжсон нэг л сонин төлөвт шилжсэн байснаа хожим ухаарч билээ.

Үдийн нэг цагт хэдхэн минут дутуу байхад тэр орчмын хамгийн өндөрлөг Сэвшигийн оройд гарч тал бүррүү дурандлаа. Таван км орчимд мотоциклтой 2 хүн бөхөс, бөхөс хийн ямар нэг зүйл хийгээд байгааг ажсан маань алсын таталттай дурантайн (телескоп) гавьяа гэхүүдээ. Мотоцикл, машинтай хэсгүүд нөгөө хоёрын урд, хойноос нь довтолгов. Бартаатай хэдий ч машин 80-90 км/цагийн хурдаар чулуу шаргиулан элдэн хөөх нь айдас төрүүлмээр. Тэд мултарч чадсангүй. Говь-Алтай аймгийн Шарга сумын Хамтын хүч багийн иргэн, 60 насны сүүдэр зооглож яваа Г.Батнасан гэгч, хүүтэйгээ хавхчилж яваа нь энэ санж. Г.Батнасан гуай 3 ширхэг хавх тавьсан нь үнэн, нэг ч тарвага агнаагүй гэж мэлээж, мэтгэлцсээр 3 цаг барсны эцэст ганцханыг агнасан гэж ам өгөв. Хэсгийн төлөөлөгч Х.Батсайхан хүний бурууг өөрөөр нь гаргуулахдаа тун ч мэргэшсэн болох нь бидэнд үлдсэн үнэтэй сургалт, сургамж болсон. Хулгайн анчин өвөө маань хавхаа хураалгаж, 50000 төгрөгний нөхөн төлбөр төлөхөөр болов.



Шарга сумын иргэн Г.Батнасан

Гэхдээ тэрээр аргацаах, гуйх, гүрийх хослуулан хавхаа авахаар чармайж буй нь ёс бус үйлдэлдээ эмээсэн шинжгүй, харин ч азгүй тохиолдлоо энэ өдрийн мууд тохож буй нь харамсмаар. Харин дагаж яваа хөвүүн нь түүнээс өөр авай. Өвгөн буурал аавыгаа, бас өөрийгөө бууруушааж, гэмшиж буй нь гунигт харц, гутарсан төрхөөс нь илхэн уншигдаж байлаа. Цаг барсан энэ зууралдаан дунд тэр хавьд 100

метрийн эргэн тойронд тарваганы нүх нэгжиж, тавиатай байсан 12 хавх илрүүллээ. Эзэн нь хэнийг бүү мэд. Онгорхой нүх болгонд хавх тавихаар тарвага гээч амьтанд дуусахаас өөр тавилан даанч алга, юун өсөх манатай. Хавх, урхи, онилсон буу гэсээр энэ амьтан бүх орон гэрээ хүн хэмээх зэрлэгүүдийн бүслэлтэд эзлүүлжээ. Дайн дажны талбар. Хөөрхийдөө, ямархан хар ирээдүй вэ?



Яг дөрвөн цаг болж байтал маш нуугдмал газарт жижиг цагаан майхан байгааг мотоциклтой баг олж харав. Машин, мотоциклоо бартаа бараадуулаад нэг хэсэг нь хадны ёроолд хурган орчныг ажиж мэдээ өгөхөөр болов. Хэсгийн төлөөлөгч, Ирвэс-1-ийн ахлагч маань майхан руу хамаг хурдаараа жийрийсээр хүрч, шалгалт хийгээд, эзэд нь иртэл отолт хийхээр болов. Хоёр цагийн дараа ажиглалтын баг мотоциклтой хоёр эзэн ирж буй мэдээг отолтын хоёртоо хүргэлээ. Ямар ч ажиг, сэжиггүй хоёр тарвагчин майхныхаа гадаа тормоз гишгээд, нэг нь бууж, нөгөө нь мотоциклоо унтраах агшинд тарваганд тавьсан хавх гэнэт үсэрдэг шиг юм болох нь



тэр.

Тарвага хавханд оронгуутаа тонгочиж эхэлдэг бол хүн хавханд орохоороо зүрх нь зогсчихвуу гэмээр хөдөлгөөнгүй болдог аж. Говь-Алтай аймгийн Дарви сумын иргэн А.Гантулга, А.Ганболд нар тарвага хулгайлахаар ирээд нэг хонож байгаа юмсанж. Ингээд тарваганы арьс 4, буу 2, сум 40 ширхэгийг хураалгаж, 210000 төгрөгний нөхөн төлбөр, торгууль төлөхөөр болов.

Ингээд хулгар шарыг ховор амьтны жагсаалтад оруулагчдын мөрөөр мөшгөсөн сүүлчийн өдрийн тэмдэглэлээ өндөрлөө.

Ирвэс багуудын ажлаас үзэхэд тарвагыг буудаж, хавх тавьж агнахаас гадна нохойгоор бариулах, төмөр утсаар урхи тавих зэрэг хориотой аргаар агнаж байгаа нь шалгалтын явцад илэрлээ. Энэ жил 2005 онтой харьцуулахад тарваганы хууль бус агналт ихэсжээ. Тарваганы хууль бус агнуур хийж буй хүмүүсийн арга нь улам нарийсч, нууц байдалд орсон байна. Тухайлбал, зарим айл гэр орчмынхоо уул, хадны ард зуух, тогоо, арьс өвчих хэрэгсэл, сав суулгыг байнгын зэхээстэй бэлтгэсэн байв. Нууцаар агнаж ирээд “нууц бааз”-даа боловсруулалт хийж байгаагийн зэрэгцээ тарваганыхаа арьсыг хад чулуу, хураасан аргалын доогуур, гэрийн гадна, дотнох бараа, авдар савны ар гэхчлэн хаа сайгүй нуусан тохиолдол олонтоо.

Тарвагыг Монгол улсын хэмжээнд агнахыг хориглосонтой холбогдуулж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажил хангалтгүй, ялангуяа тарваганы экологи-эдийн засгийн үнэлгээ өссөнөөс иргэдэд ногдуулах нөхөн төлбөр, торгуулийн хэмжээ нэмэгдсэн гэдгийг ойлгуулах, сурталчлах явдал дутмаг байгааг онцолмоор санагдана. Хэрэв Та хууль бусаар агналт хийвэл тарвага нэг бүрд дараах нөхөн төлбөр төлнө. Үүнд бурхи - 50000 төгрөг, тарч - 65000 төгрөг, мөндөл - 85000 төгрөг. Олныг хулгайлсан хүн оцойтлоо авахуулна гэдгийг олонд хүргэх нь зүйтэй болов уу. Дээр нь торгууль нэмэгдэнэ.

Хууль бусаар ан хийдэг болон хийх гэж байгаа хүмүүст зориулан нэгэн хүний хэлсэн үгээр энэ удаагийн мэдээгээ төгсгөл болгоё.

**Хамгийн сүүлчийн модыг тасдаж дууссаны дараа  
Хамгийн сүүлчийн ургамлыг түүж дууссаны дараа  
Хамгийн сүүлчийн голыг ширгэж дууссаны дараа  
Хамгийн сүүлчийн амьтныг алж дууссаны дараа  
Хүн ТА мөнгийг идэж болохгүй гэдгийг ухаарах гэж үү?!**